**МОНГОЛ УЛСЫН
БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**

Засгийн газрын II байр, Нэгдсэн Үндэстний гудамж 5/1,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-51) 26 27 99, Факс: (976-11) 26 27 98,
Цахим шуудан:info@nird.gov.mn
Цахим хуудас: www.regional.gov.mn

2024. 11. 29 № 24/96

танай ________-ны № ________-т

НИЙТ ТЕНДЕРТ
ОРОЛЦОГЧДОД

Тодруулга хүргүүлэх тухай

Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн" УТҮГ-аас 2024 оны 11 сарын 14-ний өдөр зарласан "Төв Азийн түүх, соёлын голомт" соёлын аялал жуулчлалын цогцолборын ТЭЗҮ /Архангай, Өгийнуур сум/" (МУШС/20240103001), "Адал явдалт, тусгай сонирхлын, хил орчмын болон хил дамнасан аяллыг хөгжүүлэх Их нууруудад тулгуурласан аялал жуулчлалын тусгай бүсийн ТЭЗҮ /Увс, Хяргас сум/" (МУШС/20240103011), "Дөрвөн улирлын аялал жуулчлалын цогцолбор байгуулах ТЭЗҮ /Баян-Өлгий, Улаанхус сум/" (МУШС/20240103012), "Хил орчмын болон Хөвсгөл нуурт тулгуурласан аялал жуулчлалын тусгай бүсийн ТЭЗҮ /Хөвсгөл/" (МУШС/20240103021 ), "Зүүн бүсэд түүх, соёлын нөөцөд түшиглэсэн Халх гол, Буйр нуур, Алтан-Овоо, Ганга нуур, Шилийн Богд, Хар зүрхний хөх нуур орчмын болон хил дамнасан аялал жуулчлалын алтан гурвалжинг хөгжүүлэх, аялал жуулчлалын тусгай бүсийн ТЭЗҮ /Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймаг/ (МУШС/20240103044)-ийн үйлчилгээ үзүүлэх ажилд ирсэн тодруулгад дараах хариуг хүргүүлж байна.

| № | Тодруулга | Тодруулгын хариу |
|---|---|---|
| 1. | ТББ-ийн ТӨХ-ийн ТШЗ 19.1 дэх үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн шаардлагад Бүс нутаг судлаач/Газарзүйч нь Зөвлөх инженер, Докторын зэрэгтэй байна гэсэн байна. Одоогийн байдлаар манай улсын хэмжээнд Бүс нутаг судлаач болон Газарзүйч чиглэлээр Мэргэшсэн болон Зөвлөх инженерийн зэрэг олгодоггүй бөгөөд Бүс нутаг судлаач/Газарзүйч чиглэлийн аль нэгээр нь докторын зэрэгтэй мэргэжилтэн байна гэж ойлгож болох уу? | ТШЗ 19.1 дэх үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн шаардлагад Бүс нутаг судлаач эсхүл Газарзүйч байхаар ТШЗ-д заасан.<br>Тендерт оролцогч нь бүс нутаг судлаач эсхүл газарзүйчийн аль нэгийг санал болгож болох ба тухайн санал болгосон зөвлөх нь докторын зэрэгтэй байна. |

001524020672

| | | |
|---|---|---|
| 2. | ТББ-ийн ТӨХ-ийн ТШЗ 19.1 дэх үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн шаардлагад Газар зохион байгуулалт/Хот ба бүс нутаг төлөвлөгч мэргэжилтэй 2 мэргэжилтэн шаардсан бөгөөд нэг нь нь Докторын зэрэгтэй, мэргэшсэн инженер байна гэж заажээ. Газар зохион байгуулалт/Хот ба бүс нутаг төлөвлөгч мэргэжилтэй Докторын зэрэгтэй, мэргэшсэн инженер ховор тул энэ заалтын аль нэг (доктор эсвэл мэргэшсэн инженер)-ийг хангасан байж болох уу? | ТШЗ 19.1 дэх үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн шаардлагад туссан Газар зохион байгуулалт/Хот ба бүс нутаг төлөвлөгч мэргэжлийн аль нэгийг санал болгож болох ба тухайн санал болгосон зөвлөх нь доктор эсвэл мэргэшсэн инженер байна. |
| 3. | ТББ-ийн ТӨХ-ийн ТШЗ 19.1 дэх үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн шаардлагад "Багийн ахлагч"-Хот төлөвлөлтийн Зөвлөх эдийн засагч, Хот төлөвлөлтийн мэргэшсэн архитектор, Бүс нутаг судлаач/Газарзүйч, Газар зохион байгуулалт/хот ба бүс нутаг төлөвлөгч нь тухайн байгууллагад сүүлийн 6 сараас дээш Нийгмийн даатгал төлсөн байна гэж заасан. Мөн ТББ-ийн ТӨХ-ийн ТШЗ 19.1 дэх үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн шаардлага хэсэгт "инженер техникийн ажилтнуудын 30% нь тухайн байгууллагын нэр дээр сүүлийн 6 сарын турш НД төлсөн байна. Бусад нь гэрээт байж болно" гэж заажээ. Иймд ТББ-ийн ТӨХ-ийн ТШЗ 19.1 дэх үйлчилгээ үзүүлэх хүний нөөцөд шаардсан 12 мэргэжилтний 30% буюу 4-өөс доошгүй (аль ч мэргэжилтэн) нь тухайн байгууллагад сүүлийн 6 сар НД төлсөн бол шаардлагыг хангах гэж ойлгож болох уу? | ТШЗ 19.1 дэх үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн шаардлагад заасан багийн гишүүдийн 30% буюу 4-өөс доошгүй (аль ч мэргэжилтэн) тухайн байгууллагад сүүлийн 6 сар Нийгмийн даатгал төлсөн бол шаардлагыг хангана. Бусад багийн гишүүдийн хувьд тухайн төсөл, арга хэмжээнд гэрээ байгуулан ажиллаж болно. |

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.ЭРДЭНЭБАЯР